

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2022 оны 4 сарын 30-ны өдөр

Хурлын байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, Корпорейт Хотел энд Конвеншн центрийн хурлын танхим

Хурал эхэлсэн цаг: 14 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 18,559,603 ширхэг буюу 74.24 хувь
Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайлан танилцуулах;
3. 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;

Тэмдэглэл:

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Ард Даатгал ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ард Даатгал компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг байна. Ард Даатгал компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьд хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2022 оны 4 сарын 4-ний өдрөөр тасалбар болгосны дагуу хуралдаа оролцож байна. Мөн өнөөдөр хуралдаа биеэр ирж амжаагүй хувьцаа эзэмшигчид, эсвэл компанийн үйл ажиллагааг сонирхож буй, эсвэл хувьцаа эзэмшигч болохыг сонирхож байгаа иргэд, эсвэл нээлттэй хувьцаат компанийн хурал хэрхэн явагдаж буйг сонирхсон иргэд компанийн сошиал хаяг буюу facebook хаяг (<https://www.facebook.com/ArdInsurance/videos/680592096535331>)-р цацагдаж буй live-р орж хуралд оролцох боломжтой. Хурлын ирцийг танилцуулах, хурлын үйл явцыг ажиглах зорилгоор оролцож буй зочин өөрийгөө танилцуулах уу?

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Хүрэлцэн ирсэн Ард даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд хурлын үйл ажиллагааг эхэлье. Хурлын журмын дагуу хурлын ирцийг танилцуулна уу? Тооллогын комиссоор Блүмсбюри секьюритис ҮЦК ХХК ажиллаж байна. Г.Алтансүх та бүхэнд Ард даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Сайн байцгаана уу? Ард даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол 2022 оны 4 сарын 30-ны өдөр дугаар 22/1 Хувьцаа эзэмшигчдийн ирцийн баталгаажилт.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Саналын эрх бүхий энгийн хувьцааны 18,559,603 ширхэг буюу 74.23 хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болж байна. Баярлалаа.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Тооллогын комисст баярлалаа. Ирц хүрсэн учраас хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээе. Хурлын дэгийг уншиж танилцуулья.

Хурлын дэг:

1. 2021 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланг батлах тухай. Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах танилцуулна.
2. 2020 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай О.Одбаяр миний бие танилцуулна.
3. 2021 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батална.
4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт 20 минут үргэлжилнэ.
5. Санал авах 15 минут.
6. Тооллогын комисс саналын дүнг нэгтгэн танилцуулна.
7. Хурлаас гаргасан шийдвэрийг танилцуулна.

Танилцуулсан:

Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Өнөөдрийн хуралд ирсэн нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Тооллогын комиссоор Блүмсбюри секьюритис ҮЦК ХХК ажиллаж байгаа бол манай Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Оригил, Б.Золбоо, Б.Болорчимэг, О.Одбаяр, Ч.Ганхуял, З.Ариун нар ирсэн байна. 2021 оны Санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүгнэлт өгсөн Грешт Торнтон Аудит ХХК-ийн партнёр н.Эрдэнэцог болон бусад хүндэт зочид ирсэн байна. Та бүхэнд талархал илэрхийлье. Миний бие Г.Цогбадрах 2017 оноос эхлэн Ард даатгал ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тухайн үед манай компани хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ байсан. 2018 онд бид олон нийтэд нийт хувьцааныхаа 30 хувийг санал болгож нээлттэй хувьцаат компани болж байсан. Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал маань нээлттэй хувьцаат компани болсноос хойш болж байгаа 5 дахь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал юм. 2018 онд анхны нээлттэй хувьцаат даатгалын компани болж байсан гэдгээрээ нэлээд онцлог. Компани маань нийтдээ 100 орчим ажиллагсадтай. Энэ бүтцээрээ бид 2016 оноос хойш ажиллаж байгаа. Ажиллагсдын бүтээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллах тэл дээр анхаарч ажилладаг. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй бөгөөд хуульд заасны дагуу 3 хараат бус, 6 өрднийн гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа. 2022 оны 3 сард Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийн үйл ажиллагаанд маш их өөрчлөлтийг оруулахаар байгаа. Тус кодекс маань саяхан батлагдсан учир бид дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дэлгэрэнгүй танилцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлд хийх бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтийг оруулж ирэх болно. Төлөөлөн удирдах зөвлөл маань 3 хороотой ажилладаг бөгөөд Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо гэсэн 3 хороотой. Гүйцэтгэх захирал миний удирдлага дор Даатгалын газар, Эрсдэлийн удирдлагын газар, Санхүү удирдлага, Үйл ажиллагааны газар гэсэн газрууд ажилладаг. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд Ард санхүүгийн нэгдэл ХК нийт хувьцааны 45.4 хувийг эзэмшдэг. Ардын тэтгэврийн данс ХХК нийт хувьцааны 5.3 хувийг эзэмшдэг. Мандал капитал маркетс ҮЦК ХХК нийт хувьцааны 5.1 хувийг эзэмшиж байсан бол 4 сарын 4-ний өдөр буюу бүртгэлийн өдрөөр бүх хувьцаагаа бусдад шилжүүлсэн байна. Бусад хувьцаа эзэмшигч нар дэлгэцэнд харагдаж байна. 2021 оны 4 сард Хувьцаа эзэмшигчдийн хурлаа

хийсэн бөгөөд хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ улируулан сонгож, баталж, 2 жилийн хугацаатайгаар Төлөөлөн удирдах зөвлөл маань хүчин төгөлдөр үйл ажиллагаагаа явуулж байгаа. Дижитал нэйшн 21 арга хэмжээнд хамт олноороо амжилттай зохион байгуулж, оролцсон. Бид зөвхөн өөрсдөө санхүүгийн гүйцэтгэлийн хувьд өндөр ажиллаад зогсохгүй нийгмийн хариуцлагын хүрээнд Ид шидийн орон, Тэрбум мод төсөл, Ковид-19 халдварын үеэр улаан шугаманд ажиллаж байсан сувилагч нартаа талархах талархлын аян зэрэг олон үйл ажиллагаанд нэгдсэн. Монгол HD телевизтэй хамтран Апруентис шоу нэвтрүүлэг, Ард мэнд 360 болон Ковид-19 даатгалын шинэ бүтээгдэхүүн гаргаж, нөхөн төлбөрийн шийдвэрлэх процесс цахимд шилжин ажиллаж байна. Мөн хамгийн түгээмэл ашиглагддаг аппликэйшнд өөрийн даатгалын үйлчилгээний цэсийг оруулаах зарчмаар ажиллаж байна. Харилцагчаа таньж мэдэх баталгаажуулах зорилгоор ХУР болон ДАН системд холболтуудыг бүрэн хийсэн байгаа. Дараагийн шатанд Жолоочийн хариуцлагын даатгалыг аппликэйшнд оруулж, иргэд хүссэн үедээ өөрийн даатгалыг хийлгэх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Хамгийн баяртай мэдээ бол 2021 онд манай нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 10,151 хүрч, хувьцаа эзэмшигчдийн тоо 4 дахин өссөн гэсэн маш сайхан амжилтаар 2021 оныг үдсэн байна.

Санхүүгийн хувьд голлох үзүүлэлтийн дурдмалд нийт хоронго 34.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн жилийн мөн үеийн эцсээс 21 хувиар өссөн байна. Хувьцаа эзэмшигч та бүхний өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 18.4 тэрбум төгрөгт хүрч өссөн байна. Бид хэдийгээр ногдол ашиг тараасан, өөр бусад зардлууд гарсан боловч 5 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж чадсан. Нийт хураамжийн орлого 5 хувиар буюу 750 орчим сая төгрөгөөр өссөн. Гэхдээ орлогын тайланд гол нөлөө үзүүлдэг цэвэр хураамж нь 13.5 тэрбум төгрөгт хүрч 20 орчим хувиар мөн өссөн. Хөрөнгө оруулалтын багцыг тогтмол өгөөжтэй, өндөр ашигтай байлгахын тулд зорьж ажилладаг. Даатгалын хураамжаар орсон орлогоор ашиг хийгээд байх боломжгүй байдаг бөгөөд хохирлын харьцаа болон үйл ажиллагааны зардлаа нэмээд хосолсон харьцаа маань 100-с дээш хувь гардаг. Даатгалын компаниудын гол ашгаа үйлдвэрлэдэг цэг маань хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын багцыг зөв оновчтой удирдсанаар Хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг нэмэгдүүлж явдаг. Энэ дагуу бид хөрөнгө оруулалтын багцыг тогтмол өсгөж байгаа. Нийт нөөц сан 11.7 тэрбум төгрөгт хүрч мөн өсөлттэй гарсан. Орлого үр дүнгийн тайланг дэлгэцэнд танилцуулж байна. 2021 онд бид нийт 5,800 орчим даатгуулагчид 5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. 2020 онд энэ дүн 4,700 байсан бол нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 1,000-р нэмэгдсэн. Хохирлын хэмжээ бол ижил түвшинд барьж ажилласан байгаа. Бид татвар төлөхийн өмнө нийт 8.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж үүнээс татварт 1.1 тэрбум төгрөгийг бүртгэсэн. Ингээд цэвэр ашиг нийт 7.2 тэрбум төгрөгтэй гарсан. Санхүүгийг тайланд голлох үзүүлэлтэд авлага тодорхой хэмжээгээр нэмэгдсэн. Энэ бол ковид-19 цар тахлын үед харилцагч байгууллагуудаас авах даатгалын хураамжийг хуваарьт төлбөрийн нөхцөлтэй болгож хугацааг хойшлуулах зэргээр хойшлогдсон. Гэхдээ эдгээр нь цаг хугацаандаа бүгд төлөгдөөд явж байгаа. Хөрөнгө оруулалт 5.6 тэрбум төгрөгөөр өссөн. Хамгийн гол нөлөөтэй зүйл нь нийт эздийн өмч 5 тэрбум төгрөгөөр өссөн байгаа. Ингээд нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ баяр хүргэе.

Манай санхүүгийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт өгсөн Грант Торнтон Аудит ХХК-ийн партнёр н.Эрдэнэцог таныг урьж байна.

Грант Торнтон Аудит ХХК н.Эрдэнэцог: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Эрдэнэцог гэдэг. Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитын партнёр, Ард даатгал ХК-ийн аудитын гэрээт ажлын партнёр. Манай Грант Торнтон Аудит бол дэлхийн топ 6 аудитын зөвлөх үйлчилгээний компанийн нэг бөгөөд Монгол улсад 2019 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа. Хуучин Улаанбаатар аудит гэж компани байсан бөгөөд олон улсын аудитын шаардлагыг хангаад Грант торнтон аудит ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байгаа. Бид 2 дахь жилдаа Ард даатгал ХК-д аудит хийж байгаа бөгөөд аудитаар Компанийн тухай хууль болон бусад хуульд зааснаар хувьцаат компанид хяналт тавьдаг 2 субект байдаг. Нэгт нь бол хувьцаа эзэмшигч та бүхэн, Төлөөлөн удирдах зөвлөл аудитын хорооны бүтцээр дамжуулан хяналт тавьдаг. Хоёрт хөндлөнгийн аудит байдаг. Хөндлөнгийн аудитын гаргасан дүгнэлт, санхүү тайлан баланс нь үнэн зөв эсэх, дотоод хяналтын систем нь зөв зохион байгуулалттай эсэх, гаргаж байгаа цэвэр ашиг зөв эсэхийг хөндлөнгийн аудит баталгаажуулж, баталгаажуулсан дүн дээр ногдол ашгаа зарлаж явдаг. Аудитын явцад бид томоохон 3 асуудал дээр анхаарал хандуулсан. Тэр нь компанийн удирдлагын баталсан томоохон тооцоолол, шийдэл бөгөөд эдгээр асуудлыг давтан шалгасан. Энэ нь даатгалын компанийн нэг онцлог бол даатгалын нөөцийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Даатгалын нөөц гэдэг бол ирээдүйд гарах янз бүрийн эрсдэл, нөхөн төлбөрийг хангалттай нөхөхүйц хэмжээний даатгалын нөхөн төлбөрийг бүрдүүлсэн байх ёстой. Үүнийг актуар тооцооллын үндсэн дээр магадлал тооцоолж гаргадаг. Үүнийг аудит шалгахдаа хараат бус, хөндлөнгийн мэргэжлийн актуарчийг ажиллуулж давтан тооцоолох байдлаар шалгадаг. Ард даатгал ХК-ийн хувьд даатгалын нөөцийг хангалттай хэмжээнд байгуулсан нь шалгалтаар тогтоогдсон. Олон нийтийн хувьцаат компани гэдэг утгаараа даатгалын хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үр ашигтай зохион байгуулах ёстой. Үүний тулд маш сайн дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байх ёстой. Аудитор бол мэдээж дотоод хяналтын систем нь үр ашигтай эсэх, хөрөнгө өр төлбөрөө зохистой зарцуулдаг эсэх дээр хяналтын тест явуулж, үүн дээр хангалттай хэмжээний үнэлгээ авсан байгаа. Аудитыг бид 2 үе шаттай хийж байгаа. Нэг нь завсар үеийн аудит буюу 3-р улирлын санхүүгийн тайлан гарсны дараа завсар үеийн аудит хийгээд жилийн эцсийн аудитыг санхүүгийн тайлан гарсны дараа хийдэг. Энэ бүх хугацаанд 8 хүний бүрэлдэхүүнтэй, 2 сар гаруй хугацааны турш манай аудитын баг ажилласны эцэст санхүүгийн тайланд зөрчилгүй буюу Эерэг дүгнэлт өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл санхүүгийн тайлан нь санхүүгийн Олон улсын стандартад нийцсэн, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад байгууллагаас баталсан дүрэм, журмын хүрээнд зохистой илэрхийлэгдсэн байна гэж үзэж эерэг дүгнэлт өгсөн байгаа. Ард даатгал ХК олон нийтийн компани, нөгөө талаасаа Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээд гэдэг утгаараа Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яамнаас баталсан даатгалын багц дүрэм, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэлт өгсөн байгаа. Баярлалаа.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Асуулт асуух, санал хэлэх хүн байна уу? Асуулт асуух, санал хэлэх хүн байхгүй байгаа учир хурлын дэгийн дагуу цааш үргэлжлүүлэе. Төлөөлөн удирдах зөвлөл 2020 оны цэвэр ашгаас олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах бөгөөд үүнийг миний бие танилцуулъя. 2021 онд олгосон ногдол ашгийн тайлан. Ард даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 сарын 10-ны өдрийн 1/21 дүгээр тогтоолын дагуу компани 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 40 төгрөг буюу цэвэр ашгийн 48.15 хувь, нийт 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар

шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар Ард даатгал ХК-ийн хувьцаа эзэмшиж байсан нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо. Компанийн зарласан ногдол ашгийг 2021 оны 7 сарын 2-ны өдөр Үнэц цаас төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай ногдол ашиг зуучлуулан тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлсэн.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: 2021 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл өнгөрсөн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ганхуяг /Ард санхүүгийн нэгдэл ХК-ийн гүйцэтгэх захирал/, ердийн гишүүн О.Одбаяр /Ард санхүүгийн нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн гишүүн/, ердийн гишүүн Б.Золбоо /Ард санхүүгийн нэгдэл ХК-д Санхүү эрхэлсэн захирал/, ердийн гишүүн Г.Цогбадрах /Ард даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал/, ердийн гишүүн С.Оргил /Мост Финтек ХХК-ийн захирал/, ердийн гишүүн Ч.Ганзориг /Ард Экс ХХК-ийн Гүйцэтгэх захирал/, хараат бус гишүүдээр З.Ариун /УБ дахь Америк сургуульд зөвлөх/, И.Сэр-Од /Монголын бизнесийн зөвлөлийн захирал/, Б.Болорчимэг /Өрөг.мн үүсгэн байгуулагч/ гэсэн бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн үүргийг хувьцаа эзэмшигчдийн өмнөөс гүйцэтгэсэн байна. Бид хороонд хуваагдан ажиллаж байгаа бөгөөд Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдээр Ч.Ганзориг, Б.Болорчимэг, З.Ариун нар ажиллаж байгаа. Нарийн бичгийн даргаар нь Батцэнгэл. Санхүү, эрсдэл хөрөнгө оруулалтын хорооны гишүүд Б.Золбоо, С.Оргил, Г.Цогбадрах, нарийн бичгийн даргаар Г.Баярбат нар ажиллаж байна. Аудитын хороо О.Одбаяр, З.Ариун, И.Сэр-Од, нарийн бичгийн даргаар Бямбасүрэн нар ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд бид 5 удаа ээлжит хуралдсан, нэг удаа ээлжит бусаар, нэг удаа эчнээгээр тус тус хуралдаж зохих шийдвэрүүдийг гаргаж ажилласан байна. Компанийн үйл ажиллагаа болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа өнгөрсөн хугацаанд ямар нэгэн байдлаар тасалдаагүй. Ард даатгал ХК-ийн удирдлагын баг бизнес төлөвлөгөө батлах, стратеги төлөвлөгөө батлах, санхүүгийн тайлан хэлэлцүүлгийг батлах, аудитын дүгнэлтийг хянах зэрэг бүх үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөл амжилттай удирдан зохион байгуулсан гэдгийг нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хэлмээр байна. Ард даатгал ХК дээр хувьцаа эзэмшигчдээ төлөөлөөд нэмж нэг зүйл хэлэхэд хараат бус гишүүн маань хараат бус үйл ажиллагаагаа маш сайн явуулдаг, компанийн засаглалын хувьд маш тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, тогтвортой өсөлтийг үйл ажиллагаандаа үзүүлж байгаа сайн засаглалтай компани шүү гэдгийг хэлэхэд таатай байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа бөгөөд компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлд Хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс бүх талаар дэмжин, Компанийн засаглалын кодексийг мөрдөж, ил тод нээлттэй ажиллаж, тавьсан зорилго зорилтоо биелүүлж ажиллахыг үүрэгдсэн бөгөөд цахим шилжилт, цахим даатгалын үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх, чанарын үзүүлэлтүүдийг зах зээлийн тэргүүн түвшинд барьж явах чиглэл өгч ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Хэлэлцсэн тайлантай холбогдуулан асуух асуулт болон хэлэх санал байна уу? За онлайнаар ирсэн асуултууд ирсэн байна үүнд хариулъя.

Онлайнаар ирсэн асуулт: Ямар шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх вэ? Зах зээлээ хэрхэн тэлэх вэ?

Хариулт Г.Цогбадрах: Ковидын өр нөлөө, дайны нөхцөл байдлаас болоод даатгалын компаниуд даатгалын нөхцөлд маш их өөрчлөлт оруулж байгаа. Ялангуяа хохирлын хэмжээ он гарсаар маш хүнд байгаа. Автомашинуудын сэлбэг орж ирэхээ больсон, өнгөрсөн жил байсан сэлбэгийн үнэ 50-100 хувь нэмэгдсэн байгаа. Үүгээр дамжин даатгалын компанийн олгож байгаа нөхөн төлбөрийн дүн нэмэгдэх хандлагатай болсон. Ийм учраас бид хамтран ажиллаж байгаа зуучлагч болон төлөөлөгч нартайгаа зарим нэгэн шимтгэлийн хураамжийг бууруулах тал дээр Даатгалын холбоотой хамтран ажиллаж байгаа. Цаашлаад тодорхой хэмжээний бодлогуудад өөрчлөлт оруулахыг зорьж ажиллаж байгаа. Үүнээс гадна бид харилцагчийнхаа тоог нэмэх, иргэдийн хураамжийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр та бүхэнд аль болох ойр байхын тулд цахим үйлчилгээг илүү их санал болгож ажиллахаар төлөвлөж байгаа. Цахим үйлчилгээ болон бусад төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг аппликэйшн дээрээ шинээр нэмж оруулаад, ямар нэгэн чирэгдэл хүндрэлгүй даатгалын үйлчилгээг авах боломжоор бүрэн хангаж ажиллахаар зорьж ажиллаж байна.

Онлайнаар ирсэн асуулт: Хөрөнгө оруулсан хувьцааны багцийг танилцуулж болох уу?

Хариулт Г.Цогбадрах: Багц дээр бид маш олон төрлийн багцийг бүрдүүлсэн байдаг. 2021 онд Баянгол зочид буудлын хувьцаа байснаа зарсан, Би Ди Сек ХК-ийн хувьцаа байсан түүнийгээ зарж борлуулсан, Мах импекс ХК-ийн хувьцаагаа мөн зарсан. Өнөөдрийн байдлаар манай дээр Үндэсний хувьчлалын сан, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа байгаа бөгөөд 11 хувийг Ард даатгал ХК дээр эзэмшиж байгаа. Мөн Ард санхүүгийн нэгдэл ХК болон Ард кредит ППСН ХК-д багахан хэмжээний хөрөнгө оруулалт хийж, хувьцаа эзэмшдэг. Тэдгээр нь төлбөрийн чадвар тооцохдоо бусад хөрөнгө хэсэгтээ бүртгэгдээд төлбөрийн чадвар хэсэг дээр орж ирдэггүй.

Онлайнаар ирсэн асуулт: Койноор даатгалын үйлчилгээ авч болох уу? Ард аппликэйшний хэрэглэгчийн баазаа яаж үр дүнтэй ашиглах вэ?

Хариулт Г.Цогбадрах: Яг олоодрийн байдлаар койн толбор тооцооны хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа тул төлбөр тооцоонд авах асуудал маань ээдрээтэй байгаа. Ард аппликэйшний хэрэглэгчийн баазыг нэгтгэх ажил явагдаж байгаа. Энэ нь цахим даатгал, цахим финтекс компанийн үндсэн суурь болох сстой. Үүн дээр бусад компаниудтайгаа тусдаа интеграци хийгээд явна. Бидний үйл ажиллагаандаа хөтөлж, хэрэглэж байгаа програмууд өөр өөр байдаг учраас шууд нэгтгэгддэггүй.

Онлайнаар ирсэн асуулт: Эрүүл мэндийн даатгалд хэд хүртэлх насны хүн хамрагдах боломжтой вэ?

Хариулт Г.Цогбадрах: Одоогоор 60 хүртэлх насны хүн хамрагдаж байгаа.

Онлайнаар ирсэн асуулт: Ирэх жилийн ашиг орлогын таамаглал хэр байна вэ?

Хариулт Г.Цогбадрах: 2022 он гарсаар 1-р улирал саяхан өнгөрсөн байгаа. Бид 1-р улирлынхаа тайланг харж байхад өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 20 орчим хувийн өсөлттэй байгаа. Удахгүй та бүхэнд онлайнаар лайв хийдэг earnings call-р танилцуулна. Хураамжийн орлого өсөлттэй явж байгаа бөгөөд үүнийг дагуу сэлбэгийн үнийн өсөлттэй уялдуулаад нөхөн төлбөрийн хохирлын тоо болон үнэ өсөлттэй байгаа. 1-р улирлын байдлаар бид 52 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байна. Мөн хөрөнгө оруулалтын

багцад маань эзэлдэг хувьцаанууд компанийн үр ашигт нэлээд нөлөө үзүүлдэг. Бид өнгөрсөн жилийн 1-р улиралд хэрэгжүүлээгүй цэвэр ашиг 6 тэрбум төгрөг гэж танилцуулж байсан бол өнөөдөр энэ жилийн байдлаар 52 сая төгрөгийн цэвэр ашигтай байгаа. Гэхдээ бид он дуусахад санхүүгийн төлөвлөлтийн дагуу 3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана гэсэн зорилттой байгаа. Энэ зорилтдоо хүрч ажиллана гэдэгтээ бүрэн дүүрэн итгэлтэй байна.

Онлайнаар ирсэн асуулт: Ямар шалтгаанаар Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашгийг цэвэр ашигтай харьцуулахад багаар тогтоосон бэ?

Хариулт Г.Цогбадрах: 2021 онд манай компани 7.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэж түрүүн танилцуулсан. Үүнээс 5 тэрбум төгрөг нь хэрэгжүүлээгүй ашиг юм. Нэг ёсондоо бид бодитоор хэрэгжүүлээд ашгаа аваагүй байгаа учраас үүнийгээ орхиод яг хэрэгжүүлсэн ашиг 2 тэрбумын тал гэж үзээд түүнээсээ бид 1 тэрбум төгрөгийг 2022 онд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар манай Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргаад ажиллаж байгаа. 7 сарын 30-ны өдрийн дотор хуваарилах ёстой учир түүнээс өмнө хуваарилагдах боломжтой байгаа.

Онлайнаар ирсэн асуулт: 2022 оны бизнес төлөвлөгөөнд хувьцаагаа зах зээлээс худалдан авах замаар хувьцаагаа халааслах зорилт байгаа юу?

Хариулт Г.Цогбадрах: Яг одоогийн байдлаар хувьцаагаа халааслах тухай албан ёсны шийдвэр гараагүй байгаа. Зах зээлийн нөхцөл, хөрөнгийн зах зээлийн өсөлт энэ чигээрээ өсөлт үзүүлж чадах эсэхээс хамаараад тухайн үедээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргаад халааслах эсэхээ шийдэх байх. Одоогийн байдлаар халааслах төлөвлөгөө, зорилт байхгүй байгаа.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Өөр нэмэлт асуулт ирээгүй байна. Ийм учраас хурлын дэгийн дагуу санал хураалт явуулах цагаа эхлүүлье. Санал хураалтыг 15 минутын турш авна. Саналын дүнг нэгтгээд танилцуулах болно.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: За санал хураалт дууссан байна. Одоо тооллогын комиссын дарга Алтансүх санал хураалтын дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №22/2

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай санал хураалтад 18,559,603 ширхэг буюу 74.24 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1. Зөвшөөрсөн 18,521,952 ширхэг буюу 99.8%;
 - 1.2. Татгалзсан 945 ширхэг буюу 0.00%;

1.3.Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.0% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

2. Хүчингүй болсон саналын хуудасны тоо:

2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтад санал өгсөн 3 хувьцаа эзэмшигчдийн 9,783 санал хүчингүй байна.Цахимаар санал өгөөгүй болон хугацаандаа өгөөгүй 26,923 ширхэг хувьцаа байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр: Тооллогын комиссын дарга Алтансүх танд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/22

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2022 оны 4 сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, Ард Санхүүгийн Пэгдэл ХК-ийн удирдлагын багт талархнаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчид баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэглэж байна.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн.

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯРБАТ